**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 27 өдөр Дугаар А/816 Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “б”, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020” хөтөлбөрийн 1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллааны төлөвлөгөөг (2019-2022 он) хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж хэрэгжилтийн явц, үр дүнг бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын гадрын дарга Т.Ариунболд, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

011101563

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/316 дугаар захирамжийн хавсралт

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2019-2022 он/

| № | Гүйцэтгэлийн үзүүлэлт | | | Хариуцах нэгж ажилтан | Гүйцэтгэх хугацаа | Шаардлагатай хөрөнгө сая/төг |
|---|---|---|---|---|---|---|
| | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | | | Эх үүсвэр |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд** | | | | | |
| 1. | Дэлхийн Өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг хамгаалах менежментийн төлөвлөгөө шинэчлэн, дурсгалт газрыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах | Хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан байна. | Аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл буурч, соёлын өв хамгаалагдсан байна. | Аймгийн Аялал жуулчлалын холбоо,<br>Дэлхийн-өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа | 2020 | Улсын төсөв |
| 2. | Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад харилцаа, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | Гадаад харилцаа өргөжсөн байна. | Гадаад жуулчдын тоо нэмэгдсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар,<br>Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аймгийн Аялал жуулчлалын холбоо | 2019-2022 | Улс, Орон нутгийн төсөв |
| 3. | Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний салбарын урт, богино хугацааны сургалтуудыг зохион байгуулж, хүний нөөцийг нэмэгдүүлэх | Зочлох үйлчилгээний мэргэжлийн ажилтан бэлтгэгдсэн байна. | Зочлох үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар,<br>Аймгийн аялал жуулчлалын холбоо | 2019-2022 | Улс, орон нутгийн төсөв |
| | **Хоёр. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд** | | | | | |
| 1. | Аялал жуулчлалын томоохон цогцолбор төвүүдийг байгуулж, тэдгээрийг түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээний нэр төрлийг | Аялал жуулчлалын цогцолбор төвүүд байгуулагдаж, үйлчилгээний | Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, жуулчны тоо нэмэгдсэн | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшил | 2019-2022 | Улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, Хувийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдсэн байна. | | | | хэвшил |
| 2. | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшилд стандартчилал тохирлын үнэлгээг тогтмол зохион байгуулах | Тохирлын үнэлгээг тогтмол зохион байгуулсан байна. | Жуулчдын аюулгүй, тав тухтай аялах нөхцөл бүрдсэн байна. | Тохирлын үнэлгээний ажлын хэсэг | 2 жил тутам | |
| 3. | Арвайхээр, Хархорин сумдад жуулчны гудамжийг байгуулах | Аймгийн хэмжээнд 2 жуулчны гудамжтай болсон байна. | Аялагчдыг мэдээллээр хангах, нөхцөл бүрдсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 2019 - 2021 | Улс, Орон нутгийн төсөв, Олон улсын төсө хөтөлбөр |
| 4. | Арвайхээр, Хархорин сумдад аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулах, /аялал жуулчлалын вэб сайтыг тогтмол ажиллуулах, контент бэлтгэх/ | Аялал жуулчлалын мэдээллийн төв, контенттой болсон байна. | Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл сайжирсан байна | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 2020-2022 | |
| 5. | Дотоодын болон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Төр болон хувийн хэвшил хамтран зохион байгуулалттайгаар оролцох | Олон улсын болон улсын чанартай аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсон байна. | Жуулчдын тоо нэмэгдсэн байна. | Аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн Аялал жуулчлалын холбоо | 2019-2022 | Орон нутаг, хувийн хэвшлийн хөрөнгө |
| 6. | Тусгай хамгаалалттай газар болон аялалын гол үзмэрүүдийн дэргэд оновчтой тайлбар бүхий мэдээллийн самбаруудыг байрлуулах, шинэчлэх | Монгол, англи хэл дээр тайлбар бүхий самбартай болсон байна. | Жуулчдын тав тухтай аялах орчин бүрдсэн байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Дэлхийн өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа | 2019-2022 | Орон нутгийн төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр |
| 7. | Эрдэнэ зуу музей, Төвхөн хийд, Хүрхрээ, Найман нуур орчмын угтах орчинг тохижуулах | Эрдэнэзуу музей, Төвхөн хийд, Хүрхрээ орчмын угтах орчин сайжирсан байна. | Тав тухатай аялах нөхцөл бүрдэж, байгаль орчин үзүүлэх сөрөг нөлөөлөл буурсан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Германы “Биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох нь” /KFW/ төсөл | 2019-2022 | Улс, орон нутгийн төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8. | Аяллын батлагдсан зам маршрутын дагуу үдлэх, хоноглох, бие засах газар, түр буудаллах үйлчилгээний цэгүүдийг байгуулж, замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах | Үйлчилгээний газруудын тоо нэмэгдсэн байна. | Жуулчдын аюулгүй, тав тухтай аялах нөхцөл бүрдэнэ. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сумдын Засаг даргын Тамгын газар | 2019-2022 | Олон улсын төсөл хөтөлбөр, Хувийн хэвшил |
| 9. | Арвайхээр-Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалангын засмал замын зураг төсвийг болон говийн чиглэлийн аялал жуулчлалын хатуу хучилттай зам барьж байгуулах | Арвайхээр-Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгаланг холбосон засмал замтай болсон байна. | Жуулчдын аюулгүй тав тухтай аялах нөхцөл бүрдэнэ. | Аймгийн Засаг даргын Тамгын газар | 2019-2022 | Улсын төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр |
| 10 | Орон нутгийн аялал жуулчлалын зочлох үйлчилгээний салбарын ур чадварыг дээшлүүлэх, жуулчдад үйлчлэх морин хөтөч нарыг гэрчилгээжүүлэх | Ердийн хөсгийг гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулсан байх. | Жуулчдын аюулгүй тав тухтай аялах нөхцөл бүрдэнэ. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аймгийн Аялал жуулчлалын холбоо | 2019-2021 | |
| Гурав. Аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд | | | | | | |
| 1. | Жуулчдад зориулсан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг хөнгөлөлттэй зээлд хамруулж, аймгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, борлуулах цэгүүдийг нээх | Жуулчдад зориулсан бэлэг дурсгалын бүтээгдэхүүний нэр, төрөл нэмэгдсэн байна. | Аялал жуулчлалын салбарын ажлын байрны тоо нэмэгдсэн байна. | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Сумдын Засаг даргын Тамгын газар Худалдаа аж үйлдвэрлэлийн танхим | 2019-2022 | Улс, орон нутгийн төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр |
| 2. | Агро-аялал, эрүүл мэндийн аялал хөгжүүлэх боломж, нөөцийг судлах | Судалгааг холбргдох газруудтай хамтан хийсэн байна. | Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар | 2020 | Олон улсын төсөл хөтөлбөр |
| Дөрөв. Аялал жуулчлалын арга хэмжээ /эвент/-г нэмэгдүүлж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд | | | | | | |
| 1. | Торгоны зам-Хархорум хот, Монгол эсгий урлалын | Эвент арга хэмжээнүүдийг | Нутгийн иргэдийн өрхийн орлого | Байгаль орчин, аялал жуулчлалын газар Сумдын | 2019 - | Улс, орон нутгийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | баяр, Сарлагын баяр, Тэмээний баяр, Мөсний баяр зэрэг эвент арга хэмжээнд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | нутгийн иргэдэд түшиглэн зохион байгуулсан байх. | нэмэгдэх боломж бүрдсэн байна. | Засаг даргын Тамгын газар, Аймгийн аялал жуулчлалын холбоо | 2022 | төсөв |
| 2. | Тусгай сонирхлын аялагчдад зориулсан хоноглох, отоглох цэгүүдийг бий болгон тэмдэгжүүлж, мэдээлэл үйлчилгээгээр хангах. | Аялал жуулчлалын бүс нутагт 3-аас доошгүй мэдээллийн цэг бүхий отголох цэгүүдийг бий болгосон байна. | Тусгай сонирхлын аялагчдын аялах нөхцөл бүрдсэн байна | Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа | 2019-2022 | Олон улсын төсөл, хөтөлбөр |
| 3. | Аймаг сумдын наадмыг тогтсон өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлж, аялал жуулчлалын цаглабарт оруулах | Аялал жуулчлалын гол бүс нутгийн сумдын наадмыг цагалбарт оруулсан байна. | Наадмыг зорин ирэх жуулчдын тоо нэмэгдсэн байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар Сумдын Засаг даргын Тамгын газар, Аймгийн аялал жуулчлалын холбоо | 2020 | - |
| 4. | Эрдэнэзуу хийдийн уламжлалт цам, нийслэлийн анхны шав тавьсан Ширээт цагаан нуур, Шанхын хийдэд хадгалагддаг Монгол улсын тусгаар тогтнолын Шар туг, Хархорин сумын археологийн олдворуудыг ил гаргах зэрэг аялал жуулчлалын нөөцүүдийг түшиглэн дотоодын аялагчдыг татах эвент арга хэмжээнүүдийг нэмэгдүүлэх. | Аялал жуулчлалын эвент арга хэмжээний тоо нэмэгдсэн байна. | Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, жуулчдын тоог нэмэгдсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар,<br>Дэлхийн-өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа,<br>Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа,<br>Боловсрол, соёл урлагын газар | 2020-2021 | Улс, орон нутгийн төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр |
| 5. | Уул, хад, мөсний авиралт, | Улсын | Зорин ирэх | Байгаль орчин, аялал | | Улс, орон |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | шувуу ажиглах, авто уралдаан, ангийн агаарын бөмбөлгийн гэх мэт тусгай сонирхлын аяллыг хөгжүүлэх | чанартай томоохон уралдаан тэмцээнүүдийг орон нутагт зохион байгуулах нөхцлийг с | жуулчдын тоо нэмэгдэж, нутгийн иргэд орлого олох боломж бүрдсэн байна. | жуулчлалын газар Сумдын Засаг даргын Тамгын газар, Аймгийн аялал жуулчлалын холбоо, Мэргэжлийн холбоод | 2019-2022 | нутгийн төсөв, Олон улсын төсөл хөтөлбөр |
| 6. | Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжуудыг судлан, санал санаачлагыг дэмжих. | 3-аас доошгүй эвент арга хэмжээг зохион байгуулсан байна. | Аялал жуулчлалын улирлын хамаарал багасч, жуулчдын тоо нэмэгдсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар,Байгаль орчин, аялал жуулчлалын газар Сумдын Засаг даргын Тамгын газар, Аймгийн аялал жуулчлалын холбоо | 2019-2022 | Улс, орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр |

-o0o-